



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/191

Улаанбаатар хот


Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны  
“Био-Асралт” ӨЭМТ-ийн данс бүртгэлээс  
тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 6,254,000.0 /зургаан сая хоёр зуун тавин дөрвөн мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьундай Аксент маркийн 18-60 УБЦ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны “Био-Асралт” өрхийн эрүүл мэндийн төв /Д.Нарантуяа/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны “Био-Асралт” өрхийн эрүүл мэндийн төв /Д.Нарантуяа/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ